

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

Дүүрэн

(аян замын тэмдэглэл)

Уудам. Энэ үг монголын их хээр талд л зохино. Хоёр жилийн өмнө нэг польш залуу надтай уулзахдаа “Энэ сайхан газар нутгийг хараач! Сайхан юм, даанч хоосон оргиод байна. Манайхан бол шуудхан байшин бариад дүүргэчих байсан” гэж билээ. Тийм ээ, элчилгүй уудам тал, өргөн их говийн дунд зогсоход хоосноос өөр юу ч үгүй, ялангуяа иргэншлийн энэ зуунд. Гэвч тэр хоосон зай юугаар дүүрэн байдаг вэ гэдгийг нүүдэлчид хамгийн сайн мэднэ. Анхандаа юу ч үгүй мэт мэдрэгдэх хоосон ахуй, цаг хугацаа ч урсдаггүй гэмээр санагдана. Гэвч тэнд амар амгалан амьдрал бий. Нэгээс нөгөөд шилжих нүүдэлчин түмний эрх чөлөөгөөр дүүрэн халуун дулаан сэтгэл ч бий.

Хоосон цэнхэр дэлхий юугаар дүүрэн байсныг бид мэднэ. Хараад ханашгүй ой модод, уул нурууд, ус мөрөн, далай тэнгис, ургамал амьтад гээд юу эсийг нэрлэж барах вэ. Гэвч эх орны минь нэгээхэн хэсэг Увсын цэнхэр уулс дунд нэгээс нөгөө оргил өөд холбогдсон шилэн гүүр байхгүй. Өндрөөс үсэрч эр зориггоо гайхуулах, айдсаа даван туулахыг мөрөөдөгсдөд зориулагдсан өндөр цамхаг, агаараар явагч үгүй. Тэнд хад асгын нурах чимээ нь нам гүмийг хааяахан эгшиглүүлэх янгирын сүрэг, өндрийн салхи залгилан жигүүрлэх бүргэд шувууны эрх чөлөө бий. Хүний хөл хүрээгүй мэт амгалан налайх эх байгалийн сүр жавхлан, онгон дагшин дүр төрхөө хадгалсан анир чимээгүй оршихуй дүнхийнэ.

Тэр хязгаарын газар бүхнийг сөөмлөн хурдалсаар алдарт Улаан даваанаас уруудахдаа машин тус бүр нэг километрийн зайтай бууцгаав. Борооны ус замын хажуугаар голдирол үүсгэн урссан нь булаг болон урсжээ. Ягаан өнгийн дээлтэй нэгэн эр үзмэн ягаан өнгийн зүсмийн морио усалж зогсоно. Цаана нь адуун сүрэг ус уучхаад даваа уруудна. “Энэ сайхан агшин л гэрэл зургийн хальсанд буух хэрэгтэй юм сан” хэмээн халаглаж явтал цаашлаад хонь, үхрээ туусан хүүхэд хөгшид ч үзэгдэв. Гэр ачаалсан үхэр тэргийг нэгэн морьтой эр хөтлөн урагшилна. Хонины ард дөрвөн настай болов уу гэмээр жаахан хүү үстэй лоовууз өмсчихсөн явна. Хүүгийн хоёр гар нь жолоогоо чангаас чанга атгачихсан бидэн рүү их л сониуч нүдээр ширтэх нь үзэгдээд өнгөрөв. Нүүдэл ажээ. Элчилгүй уудам нутгийн минь аль нэг хязгаарт ийнхүү нүүдлийн заншил одоо амьд хэвээр, орхигдож мартагдаагүйг харахаас өөр зол завшаан үгүй.

Б.Алтанхуяг “Аваас үлдсэн өвлийн дурсамжууд”

Монгол хэлний даалгаврууд

1. Цогцолбор бүрд юун тухай дүрсэлснийг зөв харгалзуулаарай.

- | | |
|------------------|--|
| 1) I цогцолбор | а. монголчуудын уламжлал, эрх чөлөөт амьдралын тухай |
| 2) II цогцолбор | б. нүүдэлчдийн уудам, эрх чөлөөт амьдралын тухай |
| 3) III цогцолбор | в. онгон дагшин байгаль, эрх чөлөөний тухай |

- A. 1а, 2в, 3б
B. 1б, 2а, 3в
C. 1а, 2б, 3в
D. 1б, 2в, 3а

2. “Элчилгүй уудам нутгийн минь” хэсгийн “элчилгүй” хэмээх үг эхэд ямар утгаар орсон байна вэ?

- A. зай талбайтай
B. ургамал ногоогүй
C. зэлүүд хүнгүй
D. өргөн уудам

3. Аль өгүүлбэрт нүүдэлчин ардын заншил тод илэрч байна вэ?
- A. Цаана нь адуун сүрэг ус уучхаад даваа уруудна.
 - B. Гэр ачаалсан үхэр тэргийг нэгэн морьтой эр хөтлөн урагшилна.
 - C. Ягаан өнгийн дээлтэй нэгэн эр үзмэн ягаан өнгийн зүсмийн морио усалж зогсоно.
 - D. Хонины ард дөрвөн настай болов уу гэмээр жаахан хүү үстэй лоовууз өмсчихсөн явна.
4. “Уудам. Энэ үг монголын их хээр талд л зохино.” хэмээсний учир юу вэ?
- A. Анхандаа юу ч үгүй мэт мэдрэгдэх учраас
 - B. Ахуй, цаг хугацаа ч урсдаггүй гэмээр санагддаг учраас
 - C. Элчилгүй уудам тал, өргөн их говийн дунд хоосноос өөр юу ч үгүй учраас
 - D. Амар амгалан амьдрал, халуун дулаан сэтгэл бий учраас
5. Эхийн дэвшүүлсэн асуудлыг зөв тодорхойлсон нь аль вэ?
- A. Эх байгалийн сүр хүчин, амар амгалангийн тухай
 - B. Цагийн байдал хийгээд нутаг усны тухай
 - C. Монгол заншил хэвээр хадгалагдан буй тухай
 - D. Нүүдэлчин түмний эрх чөлөөт амьдралын тухай
6. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэр аль вэ?
- A. Нэгээс нөгөөд шилжих нүүдэлчин түмний эрх чөлөөгөөр дүүрэн халуун дулаан сэтгэл ч бий.
 - B. ... амгалан налайх эх байгалийн сүр жавхлан, онгон дагшин дүр төрхөө хадгалсан анир чимээгүй оршихуй дүнхийнэ.
 - C. Анхандаа юу ч үгүй мэт мэдрэгдэх хоосон ахуй, цаг хугацаа ч урсдаггүй гэмээр санагдана.
 - D. ... ийнхүү нүүдлийн заншил одоо амьд хэвээр, орхигдож мартагдаагүйг харахаас өөр зол завшаан үгүй.
7. Ихэсгэн дүрсэлсэн өгүүлбэрийг олоорой.
- A. Хүний хөл хүрээгүй мэт амгалан налайх эх байгаль
 - B. Тэр хязгаарын газар бүхнийг сөөмлөн хурдалсаар
 - C. Анхандаа юу ч үгүй мэт мэдрэгдэх хоосон ахуй
 - D. Тэнд хад асганы нурах чимээ нь нам гүмийг хааяахан эгшиглүүлэх
8. Дуурайх үгийг олоорой.
- A. орших
 - B. туулах
 - C. дүнхийх
 - D. налайх
9. Олон тооны дагаврыг давхардуулан залгаж, үгийг буруу хэлбэржүүлсэн холбоо үг аль вэ?
- A. өндөр өндөр барилга
 - B. та нарын шийдвэр
 - C. эцэг эхийн хурал
 - D. бид нарын нөхөрлөл
10. “ол+чих+оод” бүтээврийн нийлцүүдийг зөв бичсэн нь аль вэ?
- A. олчихоод
 - B. олочхоод
 - C. олчихоод
 - D. олчоод

Уран зохиолын даалгаврууд

11. “Хангайн магтаал”-д “Зүүхэн талыг барин түшин гарвал” юу гэж дүрсэлсэн байдаг вэ?
- A. Ханцуйтай гарын чинээ
Хар халиун хэрэм нь
Халин дүүлээд
Халиун цагаан буга нь харайлдаад л
 - B. Хар халзан тэх
Хамаг олон гөрөөс нь
Харгалдан зөрөлдөөд
Халзан цагаан аргал нь
Багшраад байдаг гэнэ
 - C. Зүр гур нь зөрөлдөөд
Зүйл зүйлийн амьтан бужигнаад
Зурам тарвага нь
Тачигнаад байдаг
 - D. Рашаан тамир нь ханхалсан
Арван гэрийн хүн амьтны
Архаг өвчнийг эдгээсэн
Арвин баян хангай минь
12. “Хорь түмэд, Хоридай мэргэний түүхэн домог” зохиолд хун шувуун ээж хувцсаа өмсөн хун шувуу болон нисдэг билээ. Энэхүү дүрслэл нь ямар дүрслэх хэрэглүүрээр бүтсэн бэ?
- A. Амьдчилал
 - B. Ёгтлол
 - C. Хүншүүлэл
 - D. Хэтрүүлэл
13. Ц.Түмэнбаярын “Цагаан сүүний домог” туурийн зангилаа хэсгийн үйл явдлыг оновчтой дүрсэлсэн хэсгийг олоорой.
- A. Шарбаатар хүү төрсөн хэмээн тунхаглан зарласан
 - B. Шарбаатарын нүдэнд гуниг харуусал дүүрсэн
 - C. Хоёр хатан хүүхдээ ханын нүхээр сольсон
 - D. Шарбаатар хатны гэрийн зүг алхсан
14. Б.Ринчений “Шүхэрч Буньяа” зохиолд Улиастайд суух манж сайд хаана очсон байгаагаар зохиол эхэлдэг вэ?
- A. Эрдэнэ Зуугийн хийдийн ойр орчимд
 - B. Зуугийн өндөр сүмийн орой дээр
 - C. Нийслэл хүрээнд
 - D. Зуугийн цамын үест
15. “Хонины ард дөрвөн настай болов уу гэмээр жаахан хүү үстэй лоовууз өмсчихсөн явна” гэсэн өгүүлбэр ямар улиралд болсон үйл явдал вэ?
- A. зун
 - B. намар
 - C. өвөл
 - D. хавар

Үндэсний бичгийн даалгааврууд

16. Монгол бичгийг кирилл бичигт зөв буулгасныг олоорой.

- | | | |
|----------------------------------|---|-------------------------------|
| ᠨᠠᠷᠠᠨ ᠠᠳᠢᠯ ᠭᠡᠷᠡᠯᠲᠡᠭ ᠶ᠋ᠠᠭᠠᠷᠠᠢ | A | Наран адил гэрэлтэж яваарай |
| ᠨᠠᠪᠴᠢ ᠠᠳᠢᠯ ᠳᠡᠯᠭᠡᠷᠴᠢ ᠶ᠋ᠠᠭᠠᠷᠠᠢ | B | Нар адил гэрэлтэж яваарай |
| ᠨᠠᠷ ᠠᠳᠢᠯᠢᠭ ᠭᠡᠷᠡᠯᠲᠡᠭᠢᠯᠵᠢ ᠶ᠋ᠠᠭᠠᠷᠠᠢ | C | Нар адилыг гэрэлтүүлж яваарай |
| ᠨᠠᠪᠴᠢ ᠠᠳᠢᠯᠢᠭ ᠳᠡᠯᠭᠡᠷᠢᠭᠡᠭ ᠶ᠋ᠠᠭᠠᠷᠠᠢ | D | Нар адилыг дэлгэрээж яваарай |

17. Дүрс ялган бичсэн холбоо үгсийг утгаар нь зөв харгалзуулсныг олоорой.

- | | | | | | |
|-------|-------|-------|---|------------|-----------------|
| 1 | 2 | 3 | a | шувууны- | |
| ᠰᠡᠭᠡᠨ | ᠰᠡᠭᠡᠨ | ᠰᠡᠭᠡᠨ | b | -ондоо | A. 1c,d, 2a, 3b |
| | | | c | -цайх | B. 1a, 2b,c 3d |
| | | | d | нуруундаа- | C. 1c, 2b, 3a,d |
| | | | | | D. 1b,d 2a, 3c |

18. “Maᠭu йабуху-ду нөхүр хола” галигийг үндэсний бичигт зөв буулгасныг олоорой.

- | | | | |
|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|
| A | B | C | D |
| ᠮᠠᠭᠤ ᠶ᠋ᠠᠪᠤᠬᠤ ᠳᠤ ᠨᠥᠬᠦᠷ ᠬᠣᠯᠠ | ᠮᠠᠭᠤ ᠶ᠋ᠠᠪᠤᠬᠤ ᠳᠤ ᠨᠥᠬᠦᠷ ᠬᠣᠯᠠ | ᠮᠠᠭᠤ ᠶ᠋ᠠᠪᠤᠬᠤ ᠳᠤ ᠨᠥᠬᠦᠷ ᠬᠣᠯᠠ | ᠮᠠᠭᠤ ᠶ᠋ᠠᠪᠤᠬᠤ ᠳᠤ ᠨᠥᠬᠦᠷ ᠬᠣᠯᠠ |

19. “ЭГЭ” бүтэцтэй урт эгшиг орсон үгийг олоорой.

- | | | | |
|-----|-----|-----|-----|
| A | B | C | D |
| ᠡᠭᠦ | ᠡᠭᠦ | ᠡᠭᠦ | ᠡᠭᠦ |

20. “Сугалаа сугал + в” зөв холбон бичсэн нь аль вэ?

- | | | | |
|--------------------|--------------------|--------------------|--------------------|
| A | B | C | D |
| ᠰᠤᠭᠠᠯᠠᠭᠠ ᠰᠤᠭᠠᠯ + в | ᠰᠤᠭᠠᠯᠠᠭᠠ ᠰᠤᠭᠠᠯ + в | ᠰᠤᠭᠠᠯᠠᠭᠠ ᠰᠤᠭᠠᠯ + в | ᠰᠤᠭᠠᠯᠠᠭᠠ ᠰᠤᠭᠠᠯ + в |